



НИЙСЛЭЛИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 07 сарын 03 өдөр

Дугаар 0128

Улаанбаатар хот

Д.Гэрэлцэцэгт ажил хавсран гүйцэтгүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3, Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.12, Хөдөлмөрийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.2, Хөдөлмөрийн дотоод журмын 10.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Бодлого төлөвлөлтийн хэлтсийн Дотоод ажил хариуцсан мэргэжилтэн Дамдиндоржийн Гэрэлцэцэгт 2019 оны 07 дугаар сарын 03-ны өдрөөс байгууллагын архивын ажлыг хавсран гүйцэтгүүлсүгэй.

2. Д.Гэрэлцэцэгт ажил хавсран гүйцэтгэсний нэмэгдлийг албан тушаалынх нь үндсэн цалингийн 30 хувьтай тэнцэх хэмжээний нэмэгдэл хөлс олгохыг нягтлан бодогч /Б.Батцоож/-д зөвшөөрсүгэй.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Бодлого төлөвлөлтийн хэлтэс /Г.Гантүшиг/-т үүрэг болгосугай.

ДАРГА



П.БАТХҮЛЭГ

1159500056